



“Бетон зуурмаг шахах”


Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн чухал цэгүүд

Цэвэрлэгээ ба зайлуулалтын урьдчилсан анхааруулга

(1) Тээвэрлэх хоолойн цэвэрлэгээний урьдчилан анхааруулга

Тээвэрлэх хоолойг цэвэрлэх хоёр арга байдаг. Үүнд: усаар цэвэрлэх ба хийгээр цэвэрлэх. Гэсэн хэдий боловч хий тэсэрсний улмаас хийн цэвэрлэгээний арга хүнд гэмтэл учруулдаг учраас усаар цэвэрлэх аргыг санал болгоно.


агаар



Хийгээр цэвэрлэх үеийн шахсан хий тэсэрсний улмаас гарах ослын жишээ

(2) Тээвэрлэх хоолойг цэвэрлэх үед хоолойн үзүүрийг ав

Тээвэрлэх хоолойг цэвэрлэх үед аюулгүй байдлын үүднээс хоолойн үзүүрийг аваад цэвэрлэгч баригчийг тогтоогоод утас юмуу гинжээр хөдөлгөөнгүй бэхлээрэй.




Хоолойн үзүүрийг авч цэвэрлэгч цуглуулагчийг угсрах



Цэвэрлэгч цуглуулагчийн жишээ

(3) Тээвэрлэх хоолойн үзүүрийн агааржуулах хоолойг бүү хэрэглэ.



Тээвэрлэх хоолойн үзүүрийн агааржуулах хоолойг (тахир хоолой) цэвэрлэх зорилгоор бүү хэрэглэ. Хэрвээ агааржуулах хоолойг тээвэрлэх хоолойн дотор ашигласан бол тээвэрлэх хоолойн цэвэрлэгч үзүүрээс тургин гарна.



Тээвэрлэх хоолойн үзүүр дэх агааржуулах хоолойг ашигласны улмаас үүсэх ослын жишээ

(4) Юүлүүр цэвэрлэх үеийн анхааруулга

Холигчийг зогсоосны дараа л (холигч дэлбэн) юүлүүрийг тогтмол цэвэрлэнэ. Хэрвээ та холигчийг зогсоохгүйгээр ажиллавал таны гар хөл холигчид баригдаж хүнд гэмтээх юмуу үхэлд хүргэх аюултай.




Юүлүүрийн холигчид баригдсаны ослын жишээ


(5) Онцгой үед зогсоох төхөөрөмж

Онцгой үед зогсоох төхөөрөмж (холигч дэлбэн) нь хүн юүлүүрийн холигчид баригдах юмуу баригдах гэж байх үед уг товчлуурыг дарснаар бетон зуурмагийн шахуургын ажиллагааг зогсоох хажуу талд бэхэлсэн байдаг.

Юүлүүрийн торыг нээх үед харагддаг холигч дотор хүн унасантай холбоотой ослоос урьдчилан сэргийлэхийн тулд холигчийг автоматаар зогсоодог юүлүүрийн (хормой) хажууд төхөөрөмж байрлана.



Онцгой үед зогсоох төхөөрөмжийн жишээ




Автомат зогсоох төхөөрөмжийн жишээ

(6) Цилиндрийг цэвэрлэх үеийн анхааруулга

Бетон зуурмагийн хавхлагуудыг цэвэрлэх үед доголдлоос шалтгаалсан ослоос урьдчилан сэргийлэхийн тулд өөрийн биеэс хол алсын удирдлагаар хөдөлгөж цэвэрлэгээг хийгээрэй.

Мөн поршент төрлийн бетон зуурмагийн шахуургын автомашины бетон цилиндр лүү гараа бүү хий. Гар юмуу хурууг хавхлагийн төхөөрөмжид хийсний улмаас хүнд гэмтэл учруулах учраас гараа хийх үед хавхлагийг доголдуулах ослууд гарч байсан.


Бетон цилиндрт гараа бүү хий. Түүний оронд угаалга хийхийн тулд хутгуур ба өндөр даралттай ус ашигла.



Хавхлаг дотор хуруу хийсэн ослын жишээ
цилиндр цэвэрлэх үед идэвхжсэн

(7) Бетон зуурмагийн шахуургын автомашинтай ажиллах үеийн анхааруулга


Бэлэн зуурмагийн автомашиныг (бетон зуурмаг холигч машин) угааж байхдаа үлдэгдэл бетон зуурмагийг буцаах үед та тухайн автомашины юүлүүр (оролтын хэсэг) рүү авирах үед бетон зуурмаг холигч машинаас унахаас урьдчилан сэргийлэх хэрэгслийг заавал хэрэглэнэ.



Бетон зуурмаг холигч машинаас унах ослын жишээ

(8) Бетон зуурмагийн шахуургын автомашины урсгалын шугамыг шалга

Төслийн талбай болон компанийн авто зогсоол зэрэг олон зүйлтэй газруудад олон саад, үзэгдэх орчин хязгаарлагдах, нарийн газруудад осол аваараас урьдчилан сэргийлэхийн тулд бетон зуурмаг холигч машины замын хөдөлгөөнд анхаарал хандуулаарай.



Компанийн автомашины зогсоолд бетон зуурмагийн шахуургын автомашинаас шалтгаалсан зам тээврийн ослын жишээ